

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/25/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас:260512 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Аудитор Н.Нямсүрэн Утас:261628 Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn Их Наяд Аудит ХХК-ын захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Судалгааны талаар	12
4.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДБЭХС	Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем
ДЦС-3	Дулааны цахилгаан станц 3
ОХУ	Оросын холбооны улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБЦТС	Улаанбаатар Цахилгаан Түгээх Сүлжээ
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулалтын хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/663
танай _____-ны № _____-г

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ч.АМАРСАНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны 10,12 дугаар сард хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр төлбөрийн үлдэгдэлтэй хэрэглэгчид нэмэгдэж, Эрчим хүчний зохицуулах хорооноос 2025 оны 10 сард тарифын зохицуулалт хийснээс төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд худалдах, худалдан авах, дундаж тарифыг 238.45 төг/квт.ц байсныг 241.72 төг/квт.ц, 12 сард дундаж тарифыг 241.72 төг/квт.ц байсныг 249.22 төг/квт.ц болгон тус тус нэмэгдүүлснээр нэг худалдан авагчтай загварын дансны авлага 64,807.3 сая төгрөг буюу 55.4 хувиар өссөн байна.

Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний найдвартай байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/260 дугаар тушаал, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 519 дугаарт албан бичгийг тус тус үндэслэн 13,285.2 сая төгрөгийн өглөгийг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны нэг худалдан авагчийн болон экспорт, импортын тарифын 39,228.3 сая төгрөгийн сөрөг зөрүүг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт, өмнөх оны нэг худалдан авагчийн 1,520.4 сая төгрөгийн зэрэг зөрүүгээр экспорт, импортын 20,020.5 сая төгрөгийн сөрөг зөрүү хааж, тарифын зохицуулалтын нөөц хөрөнгө буюу бусад эргэлтийн хөрөнгө 57,728.4 сая төгрөг болж өмнөх оноосоо нэмэгдсэн энэ нь ДЦС-3-ын турбогенератор №9 дээр гарсан гэмтэл саатлаас болж станцын үндсэн тоноглолын техникийн боломжит чадал буурсантай холбоотой байна.

"Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А-1/1560 дугаар тогтоолын хүрээнд өмчийн бүртгэлийн мэдээллийг шинэчлэх, фото зураг болон баримтын иж бүрэн мэдээллийг системд байршуулж, хөдөлгөөний бүртгэлийг тогтмол шинэчлэх, мэдээллийн бодит байдалд хяналт тавих үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7,079,348,635.76	10,580,396,890.81
1.1.02	Дансны авлага	81,366,307,790.69	155,999,224,647.82
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	6,119,498,374.87	7,738,909,566.46
1.1.04	Бусад авлага	4,636,829.03	40,634,952.38
1.1.06	Бараа материал	386,180,871.34	343,136,361.64
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,624,808.75	9,739,357.72
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	94,958,597,310.44	174,712,041,776.83
1.2.01	Үндсэн хөрөнгө	11,750,169,218.21	11,019,011,841.65
1.2.02	Биет бус хөрөнгө	1,710,102,738.29	1,286,269,027.11
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,313,588,107.07	57,728,396,867.65
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,773,860,063.57	70,033,677,736.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	112,732,457,374.01	244,745,719,513.24
2.1.1.01	Дансны өглөг	95,632,823,132.12	226,409,268,224.97
2.1.1.03	Татварын өр	671,968,985.99	2,172,605,733.93
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	359,180,150.77	204,760,972.71
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	194,123,547.19	139,661,183.24
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	96,858,095,816.07	228,926,296,114.85
2.1.2.01	Урт хугацаат зээл	5,475,015,427.32	5,037,014,091.14
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	1,908,191,199.36	1,629,796,234.88
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	202,909,051.34	110,983,085.29
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,586,115,678.02	6,777,793,411.31
2.2	Өр төлбөрийн нийт дүн	104,444,211,494.09	235,704,089,526.16
2.3.01	Өмч - төрийн	1,811,705,231.02	1,811,705,231.02
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,804,259,515.08	1,804,259,515.08
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	140,628,482.55	137,222,400.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	4,531,652,651.27	5,288,442,840.98
2.3.09.1	Тайлант үеийн ашиг		760,134,107.16
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	4,531,652,651.27	4,528,308,733.82
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,288,245,879.92	9,041,629,987.08
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	112,732,457,374.01	244,745,719,513.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,593,236,591,905.71	2,164,164,044,974.66
02	Борлуулалтын өртөг	1,595,468,139,087.43	2,147,059,428,276.49
03	Нийт ашиг (алдагдал)	(2,231,547,181.72)	17,104,616,698.17
05	Хүүгийн орлого	362,376,451.35	385,374,747.54
08	Бусад орлого	9,009,680,779.48	10,485,073,578.21
08.1	Орлогын дүн	9,372,057,230.83	10,870,448,325.75
09	Борлуулалт, маркетингийн зардал	840,698,279.89	1,050,021,079.10

10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,914,607,699.28	3,768,962,022.23
11	Санхүүгийн зардал	118,357,973.31	110,682,528.60
12	Бусад зардал	918,825,424.02	6,619,780,550.58
12.1	Зардлын дүн	4,792,489,376.50	11,549,446,180.51
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,156,835,414.38)	(15,568,804,245.32)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз (гарз)	416,909.09	950,909.09
17.1	Олз, гарзын дүн	(2,156,418,505.29)	(15,567,853,336.23)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	191,602,167.32	857,765,507.18
19	Орлогын татварын зардал	36,486,724.78	97,631,400.02
19.1	Хойшлогдсон татварын зардал	52,092,977.07	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	103,022,465.47	760,134,107.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	103,022,465.47	760,134,107.16

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	2,769,450,271.65	5,309,599,138.33
2	НББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				1,713,080,035.85	1,713,080,035.85
3	Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	587,815,153.11	140,628,482.55	4,482,530,307.50	7,022,679,174.18
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				103,022,465.47	103,022,465.47
7	Зарласан ногдол ашиг				(53,900,121.71)	(53,900,121.71)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,216,444,361.97			1,216,444,361.97
9	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,811,705,231.02	1,804,259,515.08	140,628,482.55	4,531,652,651.27	8,288,245,879.92
10	НББ-ын бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(3,406,082.55)	(3,343,917.45)	(6,750,000.00)
11	Залруулсан үлдэгдэл	1,811,705,231.02	1,804,259,515.08	137,222,400.00	4,528,308,733.82	8,281,495,879.92
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				760,134,107.16	760,134,107.16
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,811,705,231.02	1,804,259,515.08	137,222,400.00	5,288,442,840.98	9,041,629,987.08

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,586,127,531,933.13	2,116,895,378,747.78
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,572,769,146,987.46	2,114,138,695,342.12
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,179,305.00	
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,356,205,640.67	2,756,683,405.66
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,580,274,419,355.89	2,105,654,257,729.26
1.2.1	Ажиллагсдадаа төлсөн	7,497,317,012.98	9,370,292,480.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,881,314,272.83	2,369,368,216.73
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,534,164,491,254.95	2,059,288,596,467.23
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	747,839,878.93	868,020,591.88
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	134,457,671.60	184,027,809.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	118,357,973.31	110,682,528.60
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	34,789,738,285.59	32,672,778,839.75
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	14,039,746.38	12,469,900.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	926,863,259.32	778,020,896.04
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,853,112,577.24	11,241,121,018.52
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	362,485,777.26	385,190,384.35
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	458,600.00	
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	362,027,177.26	385,190,384.35
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,799,332,220.87	2,297,947,640.10
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,152,320,894.92	1,762,462,112.30
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	647,011,325.95	535,485,527.80
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,436,846,443.61)	(1,912,757,255.75)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,844,148,174.52	771,900,722.31
3.1.4	Бусад	4,844,148,174.52	771,900,722.31
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,010,833,380.70	6,599,216,230.03
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	438,001,336.18	438,001,336.18
3.2.4	Төлсөн ногдол ашиг	53,900,121.71	
3.2.5	Бусад	6,518,931,922.81	6,161,214,893.85
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,166,685,206.18)	(5,827,315,507.72)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,249,580,927.45	3,501,048,255.05
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,829,767,708.31	7,079,348,635.76
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,079,348,635.76	10,580,396,890.81

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Нийт хэрэглээ /боловсруулалтаар	мян.кВтц	9,507,100.0	10,161,457.8	10,257,985.3	750,885.3	107.9	96,527.5	100.9
	Боловсруулалт	мян.кВтц	8,343,100.0	9,022,266.3	9,300,988.9	957,888.9	111.5	278,722.5	103.1
	Түгээлтээр	мян.кВтц	7,383,500.0	7,949,141.7	8,233,267.5	849,767.5	111.5	284,125.8	103.6
	Боловсруулалт	мян.Гкал	10,526.5	11,207.5	11,043.3	516.8	104.9	(164.3)	98.5
	Түгээлтээр	мян.Гкал	10,262.4	10,923.4	10,781.0	518.6	105.1	(142.4)	98.7
2	Нийт орлого	м.төг	14,121,362.1	18,178,329.5	18,271,594.3	4,150,232.2	129.4	93,264.8	100.5
3	Нийт зардал	м.төг	13,947,923.4	18,083,755.5	17,427,332.9	3,479,409.5	124.9	(656,422.5)	96.4
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	971,408.1	1,019,565.7	928,787.7	(42,620.4)	95.6	(90,778.0)	91.1
4	Татварын өмнөх ашиг	м.төг	173,438.7	94,574.1	844,261.4	670,822.7	486.8	749,687.3	892.7
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	103,022.5	85,116.6	760,134.1	657,111.6	737.8	675,017.5	893.0
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	3,876,626.2	5,072,415.3	5,163,785.9	1,287,159.7	133.2	91,370.6	101.8
	а/ Орлогын татварт	м.төг	36,461.8	9,457.4	176,053.2	139,591.4	482.8	166,595.8	1,861.5
	б/ НӨАТ	м.төг	1,114,195.0	1,555,618.2	1,547,194.2	432,999.2	138.9	(8,424.0)	99.5
	в/ НДШ	м.төг	1,881,314.3	2,518,269.7	2,369,368.2	488,054.0	125.9	(148,901.5)	94.1
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	821,860.6	964,012.0	1,047,070.8	225,210.2	127.4	83,058.8	108.6
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	21,986.7	21,991.7	21,986.7	0.0	100.0	(5.0)	100.0
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	616.0	2,691.8	1,909.6	1,293.6	310.0	(782.2)	70.9
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	191.9	374.5	203.2	11.3	105.9	(171.3)	54.3
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	53,900.1	25,535.0	-	(53,900.1)	-	(25,535.0)	-
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	121.0	127.0	121.0	-	100.0	(6.0)	95.3
9	Нийт цалингийн сан	м.төг	7,927,236.8	10,492,790.6	10,244,218.7	2,316,981.8	129.2	(248,571.9)	97.6
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,179.8	3,578.8	3,562.0	382.2	112.0	(16.8)	99.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.99	0.99	0.95	(0.03)	96.6	(0.04)	95.9
12	Хөрөнгө оруулалт	м.төг	2,920,202.4	2,397,810.6	2,263,234.0	(656,968.3)	77.5	(134,576.6)	94.4
13	Нийт авлага	м.төг	447,000.0	567,100.0	411,423.2	(35,576.8)	92.0	(155,676.8)	72.5
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	7,790,150.6	7,612,000.0	7,159,257.6	(630,893.0)	91.9	(452,742.4)	94.1
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	204,034.9	250,000.0	381,464.2	177,429.3	187.0	131,464.2	152.6
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	7,586,115.7	7,362,000.0	6,777,793.4	(808,322.3)	89.3	(584,206.6)	92.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК эрчим хүчний нэгдсэн сүлжээний найдвартай, тогтвортой үйл ажиллагааг хангасан хамгийн бага өртгийн шалгуурт нийцсэн, эдийн засгийн үр ашигтай оновчтой горим төлөвлөлт, диспетчерийн шуурхай зохицуулалтыг хэрэгжүүлж хэрэглэгчдийн стандартын шаардлагад нийцсэн цахилгаан, дулаанаар хангах үйл явцыг тасралтгүй хянан зохицуулах, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээний тэнцвэржүүлэлтийг хангасан системийн болон арилжааны операторын үүргийг гүйцэтгэх үндсэн үүрэгтэй Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Төрийн өмчийн 66.0 хувийг Эрчим хүчний яам, 34.0 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар эзэмшиж байна.

Компанийн үндсэн зорилго нь “Бүтээлч сэтгэлгээ, сэтгэлгээ төгс зохицуулалтыг үндэсний хэмжээнд бүрэн хангаж ажиллахад оршино” гэж дүрэмдээ заасныг хэрэгжүүлэх хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Цахилгаан, дулаан үйлдвэрлэлтийн хэмнэлттэй горим төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Үйлдвэрлэгч, дамжуулагч компаниудын технологийн үйл ажиллагааны хяналт мэдээллийн системийн тоног төхөөрөмж, диспетчерийн шуурхай холбоо, мэдээллийн сүлжээний бэлэн байдлыг хангаж шинэ техник, технологи нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулах ба нэг худалдан авачтай загварын санхүүгийн тайлан тэнцлийг хууль, тогтоомжийн дагуу гаргаж тайлагнах;
- Диспетчерийн хяналт мэдээллийн системүүдийн анхдагч тоноглолын найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах талаар харилцагч тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах;
- Компани тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчихгүйгээр зарим үйл ажиллагааг хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;
- Нэгдсэн сүлжээнд холбогдох эх үүсвэр томоохон хэрэглэгчийн цахилгаан хангамжийн горимын тооцоог хийх;
- Импорт, экспортын цахилгаан эрчим хүчний хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК Компанийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн хууль, Тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Компанийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Авлигын эсрэг хууль.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь 2024 онд шинэчлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132,013.3 сая төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	7,079,348.6	10,580,396.9	3,501,048.3
Авлага	87,490,443.0	163,778,769.2	76,288,326.2
Бараа материал	386,180.9	343,136.4	(43,044.5)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,624.8	9,739.3	7,114.5
Үндсэн хөрөнгө	17,773,860.1	70,033,677.7	52,259,817.6
Нийт хөрөнгө	112,732,457.4	244,745,719.5	132,013,262.1
Өр төлбөр	104,444,211.5	235,704,089.5	131,259,878.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,288,245.9	9,041,629.9	753,384.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	112,732,457.4	244,745,719.5	132,013,262.1

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,501.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг өссөн ба экспорт, импортын мөнгөн хөрөнгө 2,513.8 сая төгрөгөөр өссөн нь тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн данснаас ОХУ-д импортолсон цахилгаан эрчим хүчний

төлбөрийн сүүлийн 3 хоногийн үлдэгдэл харилцах дансанд төлөгдсөнөөс шалтгаалсан байна;

- Авлагын дансны үлдэгдэл 76,288.3 сая төгрөгөөр өссөн нь түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч 16 компанийн хэрэглэгчдийн төлбөр төлөх хугацаа удааширч, орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байснаас хуримтлагдсан авлага нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд үүнд “УБЦТС” ТӨХК 88,140.6 сая төгрөг, “ДБЭХС” ТӨХК 25,563.9 сая төгрөг, “ДСЦТС” ХК 9,858.2 сая төгрөг зэрэг томоохон компаниудын авлага их хэмжээгээр өссөн байна. Эдгээр байгууллагуудын хэрэглэгчдээс төлбөр төвлөрүүлэх хугацаа удааширч, орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байснаас төвлөрсөн авлагын хэмжээ нэмэгдэхэд нөлөөлсөн. Мөн ЭХЗХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн №632 дугаар тогтоолоор Төв, Өмнөд, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор хэрэглэгч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь бүрэн төлж чадахгүй, орлого төвлөрүүлэлт саатах нөхцөл үүссэн бөгөөд энэ нь түгээх компаниудын авлагыг нэмэгдүүлсэн бөгөөд 12 дугаар сарын тарифын зохицуулалтын алдагдлаас 1,679.0 сая төгрөгийн НӨАТ-ын авлага үүссэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 52,259.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 2,047.6 сая төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, буцалтгүй тусламжаар “Дезерт Солар Пауэр вуан” ХХК-наас 80.0 сая төгрөгийн 2 ширхэг лиценз хүлээн авсан, нэг худалдан авагчийн тарифын цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах үнэ өртгийн сөрөг зөрүү үүссэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 573 дугаар тогтоолоор 72 нэр төрлийн 320.8 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдлийг акталж, данснаас хассан, тайлант хугацаанд 3,282.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан;
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 131,259.9 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх өглөг 33.4 сая төгрөгөөр, татварын өр төлбөр 1,714.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой. Мөн Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний найдвартай байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/260 дугаар тушаал, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 519 дугаар албан бичгийг тус тус үндэслэн 13,285.3 сая төгрөгийн өглөгийг балансаас балансад шилжүүлэн авсан. “Нэг худалдан авагчтай загвар”-ын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд баруун бүсийн импортын цахилгаан эрчим хүчний 34,697.4 сая төгрөгийн төлбөрийг тайланд тусгасан, цахилгаан эрчим хүчний худалдан авах өртөг, импортын тариф болон ам.долларын ханш өссөн нь өглөг нэмэгдэхэд нөлөөлсөн. Түүнчлэн 2025 онд “Нэг худалдан авагч”-ийн загвар 53,414.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, импортолсон цахилгаан эрчим хүчний гаалийн татварын өглөг 672.0 сая төгрөгөөс 2,135.5 сая төгрөг болж өссөн;
- Эздийн өмч дансны үлдэгдэл 753.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд балансаас балансад шилжин ирсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байсныг залруулан бүртгэсэн 3.4 сая төгрөг буурсан, хуримтлагдсан ашиг 760.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны А/07 дугаар тушаалаар 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсныг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор тодотгосон байна.

Тайлант оны нийт орлогыг 18,178.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 18,073.7 сая төгрөгөөр, 94.5 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,397.8 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 18,271.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 17,427.3 сая төгрөгийн зардал гарган, 844.2 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 18,271.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 93.3 сая төгрөг буюу 0.5 хувиар давсан нь үйл ажиллагааны бус орлого 93.3 сая төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 17,427.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 656.4 сая төгрөг буюу 3.6 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд үйл ажиллагааны гүйцэтгэлээр 67,5 сая төгрөг, ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавартай холбоотойгоор тэвчиж болох зардлын санхүүжилтийг 146.8 сая төгрөгөөр зогсоосон, 2025 онд 127 орон тоо батлагдсан ба гүйцэтгэлээр 120-122 орон тоотой ажилласан ба орон тооны хэмнэлт үүсгэсэн 437.0 сая төгрөгийн зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 21 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 2,168.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 760.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 749.7 сая төгрөгөөр илүү байгаа нь зардлыг дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

Тайлант онд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 05 дугаар тогтоолоор компанийн урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийг төлж барагдуулах, санхүүгийн үйл ажиллагаа доголдох эрсдэл үүсэх зэрэг нөхцөл байдлыг харгалзан ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Диспетчерийн үндэсний төв ТӨХХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн тус компанийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл, үндсэн хөрөнгө, шилэн дансны мэдээлэл, зардал, богино хугацаат өр төлбөрийн тулган баталгаажуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их Наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Энхтуул, аудитор М.Мөнхзул нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Х.Ариунзул, Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Нямсүрэн, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/225 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн 1,602,608.6 сая төгрөгийн орлогоос 1.0 хувиар буюу 16,026.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.3 дахь хэсэгт заасны дагуу Диспетчерийн үндэсний төв ТӨХХК чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохгүй байх, хамтын гэрээнд зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, урамшуулал олгохгүй байх, бэлэг дурсгалын зүйл, согтууруулах ундаа худалдан авахгүй байх, зайлшгүй шаардлагатай бараа материалыг худалдан авах, нөөцлөхгүй байх, цахилгаан, дулаан, усны хэрэглээг хэмнэх, гэрэлтүүлгийг богиносгосон цагаар ашиглах, халаалтыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, албадад бичиг хэргийн зүйлсийг хамгийн бага хэмжээгээр норм тогтоох зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны үр дүнд 229.7 сая төгрөг хэмнэсэн байна.

4.4 Судалгааны талаар

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны үр дүнгийн талаар: Үүнд

1. Компаний орон тооны цомхотголын талаар

Тус компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр хурлыг тогтоолоор бүтэц орон тоог 127 ажилтнаар баталсан бөгөөд Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн А/52 дугаар тогтоолын дагуу орон тоог 9 хувиар бууруулах тогтоолын дагуу нөхөн томилгоо хийгээгүй бүтээмж, чанарын менежерийн албан тушаалыг цомхотгон 120 ажилтан ажилласан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Тус компани нь хамтын гэрээний 5.1 дэх заалтыг үндэслэн нэг өдрийн унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр, хоолны хөнгөлөлтийг 10.0 мянган төгрөгөөр баталж, тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд 396.7 сая төгрөгийг зарцуулахаас гүйцэтгэлээр 358.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 163.6 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 116.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Гадаад томилолтын судалгааны үр дүн:

Тус зардалд эхний төлөвлөгөөгөөр 105.7 сая төгрөг баталсан бөгөөд ТӨБЗГ-ын А/1254 дүгээр албан бичгийн дагуу 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоож, тодотгосон төлөвлөгөөнд 26.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр зарцуулсан байна.

5. Хэвлэл мэдээллийн судалгааны үр дүн:

Хэвлэл мэдээллээр Засгийн газрын шийдвэр, цахилгаан дулааны үнэ тариф нэмэгдсэнтэй холбогдуулан цаг үеийн шинжтэй мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, тандалт судалгааны зардалд 41.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

6. Программ хангамжийн судалгааны үр дүн:

Тус компани нь үйл ажиллагаандаа 25 нэр төрлийн 1,638.6 сая төгрөгийн өртөг бүхий программуудыг ашигладаг бөгөөд тайлант хугацааны жилийн хураамжид 7.2 сая төгрөг төлсөн байна.

Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал тус тус гараагүй байна.

4.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага Шилэн дансанд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 77 мэдээллийн 3,267.7 сая төгрөгийн 11 мэдээлэл оруулахаас 221.1 сая төгрөгийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад тус компанийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар 1,014.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж, шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан. Завсрын аудитаар 827.1 сая төгрөгийн 2 алдааг залруулсан.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 671.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн хэрэгжилтийн нотлох баримтыг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 01/1026 тоот албан бичгээр хүргүүлснийг тулган шалгахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Албан шаардлага	4	671,816.1	4	671,816.1	100.0
Нийт дүн	6	671,816.1	6	671,816.1	100.0

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Тайлант оны 10,12 дугаар сард хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний үнэ өссөнөөр төлбөрийн үлдэгдэлтэй хэрэглэгчид нэмэгдэж, Эрчим хүчний зохицуулах хорооноос 2025 оны 10 сард тарифын зохицуулалт хийснээс төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд худалдах, худалдан авах, дундаж тарифыг 238.45 төг/квт.ц байсныг 241.72 төг/квт.ц, 12 сард дундаж тарифыг 241.72 төг/квт.ц байсныг 249.22 төг/квт.ц болгон нэмэгдүүлснээр нэг худалдан авагчтай загварын дансны авлага нэмэгдсэн, тус авлагын барагдуулалт болон түүнтэй холбоотой өр төлбөрийг төлсөн эсэх;
- Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2024-2025 оны хамтын гэрээний дагуу ажилчин, албан хаагчдын тэтгэмж, буцалтгүй тусламж, орон сууцны дэмжлэг олгож байгаа эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33.6 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Балансаас балансад шилжин ирсэн 3.4 сая төгрөгийн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Үндсэн хөрөнгийг тодруулга тайланд 23.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 15 дугаар 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна, “толилуулга ба тодруулга”, “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Бараа материалыг тодруулга тайланд 5.5 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 15 дугаар 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна, “толилуулга ба тодруулга”, “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Үндсэн хөрөнгийн худалдан авалтын гэрээний дүн зөв ба орлогын баримт, худалдан авагч талын зарлагын баримтыг дүнг 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 15 дугаар 15.1.Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 217.4 сая төгрөгийн алдаа¹ илэрсэнд 2.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 212.6 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 217.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,808.7 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Тайлант онд цалинтай чөлөөтэй байх хугацаанд хавсралтад дурдсан 26 албан хаагчид 2.6 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Диспетчерийн үндэсний төвийн 2023-2024 оны хамтын гэрээний 5 дугаар хэсгийн 5.1-д “Ажилтны нэг өдрийн хоолны үнийг 18,000 төгрөгөөр тооцож, үүний 60 хувь буюу 10,800 төгрөгийг ажилтанд олгоно”, 5.2-т “Ажилтан ажилдаа ирэх, буцах унааны зардлыг хоногт 3,000 төгрөгөөр бодож олгоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Цалинтай чөлөөтэй байх хугацаанд олгосон 2.6 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 2. Тайлант оны санхүүгийн тайлан дахь 2.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй, тулган баталгаажуулаагүй анхан шатны баримтын бүрдэл хангуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Бүх нийтээр амрах буюу цагаан сарын баярын 3 өдөр ажилласан ажиллагсдыг хүний нөөц цаг бүртгэлийн системд бүртгэж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй, “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүний нөөцийн ажилтан цаг бүртгэлийн тайланг үнэн зөв ойлгомжтой хөтөлж, бүртгэл тайланг баталгаажуулж байх;

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 4. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 65 нэр төрлийн 185.1 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэр гаргуулан, бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Балансаас балансад шилжин ирсэн хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэн байна.	1	3,406.1			1	3,406.1	1	3,406.1				
Үндсэн хөрөнгийг тодруулга тайланд зөрүүтэй бүртгэсэн байна.	1	23,900.0			1	23,900.0	1	23,900.0				
Бараа материалыг тодруулга тайланд зөрүүтэй бүртгэсэн байна.	1	5,458.7			1	5,458.7	1	5,458.7				
Үндсэн хөрөнгийн худалдан авалтын гэрээний дүн зөв ба орлогын баримт, худалдан авагч талын зарлагын баримтын дүн зөрүүтэй байсан.	1	793.9			1	793.9	1	793.9				
Дүн	4	33,558.8			4	33,558.8	4	33,558.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	Цалинтай чөлөө олгосон ажилчдад хоол, унааны хөнгөлөлт олгосон байна	1	2,591.3	1	2,591.3								
2	Бүх нийтээр амрах буюу цагаан сарын баярын 3 өдөр ажилласан ажиллагсдыг хүний нөөц цаг бүртгэлийн системд бүртгэж, баталгаажуулаагүй байна.	1	27,451.1					1	27,451.1				

“Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3	Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	2,257.4			1	2,257.4					
4	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 65 нэр төрлийн 185,148.0 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	185,148.0			1	185,148.0					
Дүн		4	217,447.8	1	2,591.3	1	2,257.4	2	212,599.1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 77 мэдээллийн 3,267,745,8 мянган төгрөгийн оруулахаас 11 мэдээллийн 221,075.7 мянган төгрөгийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	221,075.7					1	221,075.7
Дүн	1	221,075.7					1	221,075.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 122/А0150092

Улаанбаатар хот

САГ- 2026/25/НА-СТА - ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Диспетчерийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалинтай чөлөөтэй байх хугацаанд хавсралтад дурдсан 26 албан хаагчид 2,591,293.28 /Хоёр сая таван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун ерэн гурван төгрөг хорин найман мөнгө/-ний хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Диспетчерийн үндэсний төвийн 2023-2024 оны хамтын гэрээний 5 дугаар хэсгийн 5.1-д "Ажилтны нэг өдрийн хоолны үнийг 18,000 төгрөгөөр тооцож, үүний 60 хувь буюу 10,800 төгрөгийг ажилтанд олгоно", 5.2-т "Ажилтан ажилдаа ирэх, буцах унааны зардлыг хоногт 3,000 төгрөгөөр бодож олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоосно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Цалинтай чөлөөтэй байх хугацаанд олгосон 2,591,293.28 /Хоёр сая таван зуун ерэн нэгэн мянга хоёр зуун ерэн гурван төгрөг хорин найман мөнгө/-ийг Диспетчерийн үндэсний төвийн ерөнхий нягтлан бодогч Т.Бямбажаваар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Диспетчерийн үндэсний төвийн Гүйцэтгэх захирал (Ч.Амарсанаа)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Багд тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Акт\2026\0316 SAG-5.Docx

1526200120



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 560/20250032

Улаанбаатар хот

СЭТ-2026/05-НА-СТА-ТӨМГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Диспетчерийн үндэсний төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Тайлант оны санхүүгийн тайлан дахь 2,257,357.72 /Хоёр сая хоёр зуун тавин долоон мянга гурван зуун тавин долоон төгрөг далан хоёр мөнгө/-ний авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант оны санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй, тулган баталгаажуулаагүй анхан шатны баримтын бүрдэл хангуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Диспетчерийн үндэсний төвийн Гүйцэтгэх захирал (Ч.Амарсанаа), ерөнхий нягтлан бодогч (Т.Бямбажав) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Х.АРИУНЗУЛ